


НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Африкийн ямар улсаас Атлантын далай руу шууд гарч болох вэ? (1 оноо)
 А. Ангол В. Мозамбик С. Чад D. Танзани E. Судан
2. Аль нь Номхон далайн дулаан урсгал вэ? (1 оноо)
 А. Гольфстрим В. Мозамбик С. Бенгель D. Канар E. Куроиси
3. Гринвичийн голдоч ямар эх газруудыг дайран өнгөрөх вэ? (1 оноо)
 А. Хойд Америк, Антарктид, Еврази В. Еврази, Африк, Хойд Америк
 С. Африк, Антарктид, Өмнөд Америк D. Еврази, Австрали, Африк
 E. Еврази, Африк, Антарктид
4. Туул гол Орхон голын хэд дэх эрэмбийн цутгал вэ? (1 оноо)
 А. 1 В. 2 С. 3 D. 4 E. Цутгал биш
5. Аль нь Цэрдийн галавт үүссэн нүүрсний орд газар вэ? (1 оноо)
 А. Могойн гол В. Налайх C. Нарийнсухайт
 D. Тавантолгой E. Хар Тарвагатай
6. Дараах аймгуудаас Оросын Холбооны Улстай хиллэдэг аймгийг олно уу. (1 оноо)
 А. Ховд В. Архангай С. Төв D. Хэнтий E. Дундговь
7. Иргэн Б сувилалд эмчлүүлэхээр Хужиртын рашаан руу явсан бол аль аймагт очсон бэ? (1 оноо)
 А. Архангай В. Булган С. Өвөрхангай D. Дундговь E. Баянхонгор
8. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Техник технологийн хувьд холбоотой, нэг төрлийн түүхий эдээр олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн нэгдлийг..... гэж нэрлэнэ. (1 оноо)
 А. Үйлдвэрийн бөөгнөрөл В. Үйлдвэрийн хоршилт
 С. Үйлдвэрийн төрөлжилт D. Комбинат E. Үйлдвэрийн цэг
9. Үндэсний аюулгүй байдал, улсын болон бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх хэмжээний, эсвэл жилд Монгол улсын Д.Н.Б-ий 5-аас дээш хувийг үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой ордуудыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
 А. Стратегийн В. Ердийн С. Түгээмэл D. Орон нутгийн E. Холимог
10. Нутгийн шилмэл омгийн хонь аль нь вэ? (1 оноо)
 А. Тулман хөхт В. Баяндэлгэрийн улаан C. Үзэмчин
 D. Өнжүүл E. Хэцийн хүрэн
11. Манай орны тээврийн салбарт зорчигч эргэлтээр тэргүүлэх салбар аль нь вэ? (1 оноо)
 А. Авто тээвэр В. Агаарын тээвэр C. Ердийн хөсөг
 D. Төмөр замын тээвэр E. Усан тээвэр
12. 1кг нефть шатахад 10.5 ккал дулаан ялгардаг бол 10 кг нефть шатахад хэдий хэмжээний дулаан ялгарах вэ? (1 оноо)
 А. 110 кал В. 105 кал С. 1050 кал D. 110 ккал E. 105 ккал
13. Нью-Йорк (Х.Ө 41°20', БУ 74°) хотоос Мехико (Х.Ө 19°30', БУ 99°) хот руу зорчигч тээврийн онгоц хөөрөв. Мехико хот Нью-Йоркоос аль зүгт орших вэ? (1 оноо)
 А. Зүүн өмнө В. Зүүн хойд С. Баруун хойд D. Баруун өмнө E. Хойд
14. Сүүлийн жилүүдэд дэлхийн улсуудыг хөгжлийн түвшнээр "Өмнөдийн" ба "Хойдын" гэж ангилах нь түгээмэл болжээ. Аль нь Өмнөдийн бүлэгт багтах улс вэ? (1 оноо)
 А. Итали В. Дани С. Финлянд D. Нидерланд E. Мексик


15. НҮБ-ын албан ёсны хэлэнд багтдаг хэлийг нэрлэнэ үү. (1 оноо)
А. Польш В. Чех С. Орос D. Португали E. Итали
16. Аливаа улс гадаадын хөрөнгө оруулалт, техник технологийг татах зорилгоор гааль татварын онцгой хөнгөлөлт үзүүлж дэмжсэн, ихэвчлэн улсынхаа хил орчимд байрлах үйлдвэрлэл үйлчилгээний онцгой бүсийг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
А. Эдийн засгийн интеграци В. Олон улсын хөдөлмөрийн газарзүйн хуваарь
С. Эдийн засгийн чөлөөт бүс D. Олон улсын тээвэр зуучлал
E. Үндэстэн дамнасан корпораци
17. Үндэс угсаа, арьстан хамаарахгүйгээр шүтдэг, “Дэлхийн шашин” гэж нэрлэгдэх 3 том шашин аль нь вэ? (1 оноо)
А. Христос, Ислам, Будда В. Христос, Будда, Хиндүизм
С. Будда, Ислам, Жайнизм D. Христос, Будда, Сикхизм E. Ислам, Христос, Даосизм
18. Өгөгдсөн улсуудаас хүн амын нягтшилаар хамгийн бага орныг сонгоно уу. (1 оноо)
А. Герман В. Япон С. Сингапур D. Казакстан E. Их Британи
19. Хонины тоо толгой, үйлдвэрлэлээр тэргүүлэгч орнуудыг тодорхойлно уу. (1 оноо)
А. Хятад, Австрали, Энэтхэг В. Япон, Иран, Түрк
С. Монгол, ӨАБНУ, Украин D. Герман, Ирланд, Конго
E. Тайланд, Пакистан, Сири
20. Цэгийг оронд тохирох үгийг сонгоно уу. ХХ зууны 40-өөд оноос эхлэн мэдээллийн технологи болон цөмийн эрчим хүч, сансрын техникийн хөгжил шинэ шатанд гарч нийгмийн харилцаа, үйлдвэрлэл, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд чанарын хувьсгал хийсэн. Энэ үйл явцыггэнэ. (1 оноо)
А. Аж үйлдвэрийн хувьсгал В. Нийгмийн хувьсгал
С. Нанотехнологийн хувьсгал D. Соёл иргэншлийн хувьсгал
E. Шинжлэх Ухаан Техникийн Хувьсгал
21. Төв Америкт байх Атлантын ба Номхон далайг холбосон тээврийн чухал ач холбогдол бүхий далайн сувгийн нэрийг сонгоно уу? (1 оноо)
А. Киль В. Панам С. Цагаан тэнгисийн D. Их Хятадын E. Суэц
22. Амазоны сав, Конгын сав, Гвинейн булангийн орнуудад хамгийн ихээр тулгамдаж буй байгаль орчны асуудал юу вэ? (1 оноо)
А. Хүчиллэг бороо В. Озоны давхаргын нимгэрэлт буюу цоорол
С. Үндэстэн хоорондын зэвсэгт мөргөлдөөн
D. Автомашинаас үүдэлтэй агаарын бохирдол
E. Халуун орны чийглэг ойн огтлолт, багасалт
23. Исландад 2011 оны 4 сард байгалийн ямар гамшигт үзэгдэл болсон бэ? (1 оноо)
А. Ойн түймэр В. Газар хөдлөл, цунами С. Галт уулын дэлбэрэлт
D. Үер E. Хар салхи
24. Хүний үйл ажиллагаагаар үүссэн рельеф (хотгор гүдгэр)-ийн төрөл аль нь вэ? (1 оноо)
А. Хөөө, шүрэн арал В. Уурхай карьер, ухсан нүх
С. Довцог, элсэн манхан D. Өрх тогоо E. Мөсөн гол, намаг
25. Нарны аймгийн бүх гараг нарыг тойрон цагийн зүүний эсрэг чиглэлд эргэдэг. Мөн тэр чиглэлд тэнхлэгээ эргэдэг боловч 2 гараг нь тэнхлэгээ эсрэг чиглэлд эргэдэг. Ямар хоёр гараг вэ? (1 оноо)
А. Буд, Сугар В. Сугар, Тэнгэрийн ван С. Сугар, Бархасбадь
D. Тэнгэрийн ван, Ангараг E. Ангараг, Бархасбадь

26. Дан ганц үндэстнээс бүрдсэн улс орны хувьд хүн амын хэдэн хувь нь нэг үндэстэн байх хэрэгтэй вэ? (1 оноо)
 А. 50% В. 90%-аас дээш С. 60% гаруй D. 75% орчим E. 25%-аас бага
27. Хурд ихтэй устөрөгчийн хий зонхилж, огторгуйн уудамд алдагддаг, тодорхой орон зайд баригддаггүй, маш сийрэг байх агаар мандлын үе давхаргыг нэрлэнэ үү. (1 оноо)
 А. Тропосфер В. Стратосфер С. Мезосфер D. Термосфер E. Экзосфер
28. Харилцан хөдөлгөөнөөс хамаарч хавтангуудын хоорондох хил зааг хэдэн янз байх вэ? (1 оноо)
 А. 2 В. 4 С. 3 D. 1 E. 5
29. Газрын зураг дээр ижил гүний утгыг холбосон шугамыг юу гэж нэрлэх вэ? (1 оноо)
 А. Изотерм В. Изогон С. Изогипс D. Изобат E. Изобар
30. Эдийн засгийн Хангайн бүсийн тулгуур хотууд аль нь вэ? (1 оноо)
 А. Эрдэнэт, Булган В. Мөрөн, Цэцэрлэг С. Арвайхээр, Мөрөн
 D. Эрдэнэт, Хархорин E. Булган, Хархорин
31. Дараах цэгийн солбицлыг тодорхойлно уу. (1 оноо)



- А. $\Theta\Theta 54^{\circ}30'$, $3У 93^{\circ}30'$
 В. $Х\Theta 53^{\circ}30'$, $БУ 95^{\circ}30'$
 С. $\Theta\Theta 55^{\circ}30'$, $БУ 94^{\circ}30'$
 D. $Х\Theta 55^{\circ}30'$, $3У 94^{\circ}30'$
 E. $Х\Theta 54^{\circ}30'$, $БУ 95^{\circ}30'$

32. Унтарсан галт уулсыг орших аймагтай нь зөв тохируулна уу? (1 оноо)
 1) Сүхбаатар А. Урантоого
 2) Архангай В. Шилийн богд
 3) Булган С. Хоргын тогоо
 А. 1А, 2В, 3С В. 1В, 2С, 3А С. 1С, 2А, 3В
 D. 1С, 2В, 3А E. 1В, 2А, 3С
33. Зурагт 1-ийн тоогоор тодруулсан Тусгай Хамгаалалттай Газар нутгийн нэрийг зөв сонгоно уу? (2 оноо)




- А. Нөмрөгийн Дархан Цаазат газар
 В. Дорнод Монголын талын Дархан Цаазат газар
 С. Шилийн Богдын Байгалийн Дурсгалт газар
 D. Онон Балжийн савын Байгалийн Цогцолборт газар
 E. Горхи Тэрэлжийн Байгалийн Цогцолборт газар

34. Дараах өгөгдлийг уншаад зөв 2 өгүүлбэрийг сонгоно уу. (2 оноо)

- 1) Цагаан будааны тариалалтын гол бүс нутаг бол Зүүн, Зүүн Өмнөд, Өмнөд Ази.
- 2) Цагаан будааг жилд 8-10 удаа хураан авдаг.
- 3) Цагаан будаа нь чийг болон дулаанд дуртай ургамал юм.
- 4) Цагаан будаа нь байгалийн ямар ч нөхцөлд ургах чадвартай.

A. 1 ба 3 B. 2 ба 3 C. 3 ба 4 D. 1 ба 4 E. 2 ба 4

35. Зураг дээр 3-ийн тоогоор тэмдэглэсэн хилийн боомтыг нэрлэнэ үү. (2 оноо)




- A. Хавирга
- B. Бичигт
- C. Эрээнцав
- D. Ульхан
- E. Бага Илэнх

36. Хамгийн дулаан сарын 0°C-ийн изотерм болон хойд өмнөд туйлын хооронд үүсэх дэлхийн дулааны бүслүүрийг нэрлэнэ үү. (2 оноо)


- A. Халуун бүслүүр
- B. Сэрүүн бүслүүр
- C. Хүйтэн бүслүүр
- D. Мөнх хүйтэн бүслүүр
- E. Бүгд

37. Зурагт А үсгээр тэмдэглэсэн уулсын тогтолцоог нэрлэнэ үү? (2 оноо)




- A. Хянганы уулс
- B. Говь Гурван Сайханы нуруу
- C. Тахийн шар нуруу
- D. Булнайн нуруу
- E. Алтайн нуруу

38. Асуултын тэмдгийн оронд байх газарзүйн объектийн нэрийг сонгоно уу. (2 оноо)




- A. Персийн булан
- B. Бискайн булан
- C. Лабрадорын булан
- D. Финийн булан
- E. Мексикийн булан

39. Монгол орны угсаатан ястнуудын голлон амьдрах нутгийг өнгөт дэвсгэрийн аргаар дүрсэлсэн зурагт 1 ба 2-ын тоогоор ямар ястныг тэмдэглэсэн бэ? (2 оноо)



- A. 1- Үзэмчин, 2- Мянгад
- B. 1- Дарьганга, 2- Захчин
- C. 1- Буриад, 2- Баяд
- D. 1- Дарьганга, 2- Дархад
- E. 1- Үзэмчин, 2- Хотгойд

40. Зургийг ажиглаад 1-ийн тоогоор заасан хавтангуудын хилийг тодорхойлно уу. (2 оноо)




- A. Ойртон нийлж буй хавтангийн хил зааг
- B. Холдон салж буй хавтангийн хил зааг
- C. Шилжин зөрж буй хавтангийн хил зааг
- D. Хавтангийн хөдөлгөөнийг судлах боломжгүй
- E. Хавтангууд хөдөлдөггүй

41. Дараах фото зургуудыг эх газартай нь зөв тохируулсныг сонгоно уу. (2 оноо)




1. **A. Африк** **B. Өмнөд Америк** **C. Австрали** **D. Хойд Америк**
 A. 1C, 2A, 3D, 4B B. 1B, 2C, 3A, 4D C. 1D, 2B, 3C, 4B
 D. 1A, 2B, 3C, 4D E. 1B, 2A, 3D, 4C

42. Байрзүйн зургийн таних тэмдгүүдийг зөв харгалзуулсан хувилбарыг нэрлэнэ үү. (2 оноо)




- A. 1B, 2A, 3C, 4D B. 1A, 2B, 3D, 4C C. 1B, 2C, 3A, 4D
 D. 1B, 2D, 3A, 4C E. 1B, 2A, 3D, 4C

43. Нарны эгц тусгалыг үзүүлсэн тахир шугам дээр А гэж тэмдэглэгдсэн хотод хэдэн сарын хэдний өдөр болж байх боломжтой вэ? (2 оноо)



- A. 9 сарын 23 B. 3 сарын 21 C. 6 сарын 22
 D. 12 сарын 22 E. 10 сарын 22

44. Энэтхэгээс Австрали хүртэл өгөгдсөн сумны дагуу (А-аас В) ертөнцийн зүг чигийг тодорхойлно уу. (2 оноо)




- A. Зүүн хойд
 B. Баруун өмнөд
 C. Баруун хойд
 D. Зүүн өмнөд
 E. Баруун

45. Хэрлэн гол тодорхой хэсэгтээ өргөн нь 50 м, гүн нь 2 м бол дундаж хөндлөн огтлолын талбайг олоорой. ($S=d \times f$) (2 оноо)


- A. 80 м^2 B. 120 м^2 C. 40 м^2 D. 100 м^2 E. 200 м^2

46. Зураг дээр 1-ийн тоогоор тэмдэглэсэн улсад голлон хөгжсөн аж ахуй, үйлдвэрлэл аль нь вэ? (2 оноо)




- A. Электроникс, химийн үйлдвэр, аж үйлдвэрийн робот
 B. Төмөрлөг, кофе, чихрийн нишингэ
 C. Дарс, хөлөг онгоц, банк санхүү, компьютер
 D. Нефть химийн үйлдвэр, даатгал, байгаль орчны үнэлгээний үйлчилгээ
 E. Боловсролын үйлчилгээ, тэмээний аж ахуй, уулын аялал жуулчлал

47. Масштабыг томоос нь жижиг рүү дараалуулан бичсэн хариултыг сонгоно уу. (2 оноо)



- A. 1, 2, 3
- B. 1, 3, 2
- C. 3, 2, 1
- D. 3, 1, 2
- E. 2, 1, 3

48. Зургийг ажиглаад эдийн засгийн Баруун бүсэд багтах аймгийг олно уу? (2 оноо)




- A. 1 ба 2
- B. 3 ба 2
- C. 2
- D. 4
- E. 6

49. Байгалийн бүс ба хөрсний хэв шинжийг зөв тохируулна уу? (2 оноо)


- | | | |
|--------------------|-------------------------------|-------------------|
| 1. Говь цөлийн бүс | A. Хүрэн | |
| 2. Тал хээрийн бүс | B. Хар шороон, ойн ширэгт | |
| 3. Ойт хээрийн бүс | C. Чандруулаг | |
| 4. Тайгын бүслүүр | D. Говийн бор, давсархаг хөрс | |
| A. 1A, 2C, 3D, 4B | B. 1D, 2A, 3B, 4C | C. 1B, 2C, 3D, 4A |
| D. 1C, 2A, 3B, 4C | E. 1D, 2C, 3A, 4B | |

50. Бриз салхи хаана тод илрэх вэ? (2 оноо)




- A. А цэг
- B. В цэг
- C. С цэг
- D. D цэг
- E. Хаана ч байж болно

51. Цээгийн оронд тохирох нэрийг сонгоно уу. Хотгор гүдгэрийн зүсэлт нь эх газрыг баруунаас зүүн тийш огтлон гарсан байна. (2 оноо)



- A. Африк
- B. Австрали
- C. Антарктид
- D. Өмнөд Америк
- E. Европ

52. Сумаар ямар бүтээгдэхүүний экспортын чиглэлийг илэрхийлж байна вэ? (3 оноо)



- A. Нүүрс B. Цай C. Гар утас D. Компьютер E. Хүнсний ногоо

53. А улсын ДНБ 2010 онд 350 сая америк доллар байсан бол 2011 онд 380 сая америк доллар болж өсчээ. ДНБ-ий жилийн өсөлт хэдэн хувь болсон бэ? (3 оноо)

- A. 9.5% B. 10.5% C. 11.5% D. 7.5% E. 8.5%

54. Газарзүйн нэрсийг тив, объектой нь зөв харгалзуулна уу? (3 оноо)

- | | | |
|--------------|-----------|-----------|
| 1. Их Рифт | A. Европ | a. Тал |
| 2. Гурон | B. Ази | b. Хойг |
| 3. Скандинав | C. Африк | c. Нуур |
| 4. Их Хятад | D. Америк | d. Хөндий |


- A. 1-Ad, 2-Dc, 3-Ba, 4-Cb
 B. 1-Cd, 2-Dc, 3-Ab, 4-Ba
 C. 1-Dd, 2-Cc, 3-Aa, 4-Bb
 D. 1-Cd, 2-Dc, 3-Aa, 4-Bb
 E. 1-Dd, 2-Cc, 3-Ab, 4-Ba

55. Манай орны зарим хотуудын жилд унах хур тунадас, агаарын температур болон гадарга, газарзүйн байрлалыг тодорхойлсон хүснэгтийг ажиглаад асуултын тэмдгийн оронд тохирох хотыг сонгоно уу? (3 оноо)

Хотууд	Өргөрөг	Өндөр (м) д.т.д	Дундаж температур (t °C)			Жилд унах тунадас(мм)
			жилийн	I сар	VII сар	
Улаангом	ХӨ 49°58'	939	-3.7°	-32°	+16°	138
Баруун-Урт	ХӨ 46°41'	981	+0.6°	-21°	+20°	203.7
?	ХӨ 46°22'	2181	-1.5°	-19°	+14°	171.2
Даланзадгад	ХӨ 43°34'	1465	+4°	-16°	+21°	129.5

- A. Улаанбаатар B. Сүхбаатар C. Өндөрхаан D. Алтай E. Чойбалсан

56. Монгол улсын хүн амын тооллоготой холбоотой тоон мэдээллүүдийг өгөв. Графикт дүрсэлсэн өгөгдлүүдийг ажиглаад өгөгдсөн хариултуудаас үнэн нэг өгүүлбэрийг сонгоно уу? \1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, ердийн өсөлт\ (3 оноо)



- A. Ердийн өсөлт ба төрөлтийн тоо хэмжээ хамгийн бага байсан нь 1944 он.
 B. Ердийн өсөлт 1963 оноос хойш тогтмол нэг түвшинд байна.
 C. 1944 онтой харьцуулахад 2010 онд нас баралтын тоо хэмжээ 2 дахин өссөн.
 D. Төрөлтийн тоо хэмжээ 2000 оноос хойш өсөөгүй буюу нэг түвшинд байна.
 E. Нас баралтын тоо хэмжээ 2010 онд хамгийн бага түвшинд байна.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Анхааруулга

- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны 2-р хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл, эцсийн хариу 5650 гэж гарсан бол a-5, b-6, c-5, d-0 гэж бөглөнө.

- 2.1. Нэгэн өвгөжөөр монгол эр АНУ-д сурч байгаа хүүхдүүд дээрээ очихоор Нью-Йорк хотын нисэх онгоцны буудал дээр буужээ. Хүлээлгийн танхим дахь дэлгэцээр 68°F гэсэн тоог хараад хэдэн хэмийн дулаан болохыг ойлгосонгүй. Хэрвээ чи байсан бол цельсийн хэдэн градус гэж тайлбарлах байсан бэ? $t^{\circ}\text{C} = 5/9 \times (t^{\circ}\text{F} - 32)$ / (3 оноо)
- 2.2. Улаанбаатар Баруун-Урт хоёрын хооронд 560 км зайтай. 5 тн даацтай машинаар барилгын материалыг 7 хоногийн турш өдөрт 2 удаа тээвэрлэсэн бол ачаа эргэлтийг тооцоорой. ($E = A \times S$) (4 оноо)
- 2.3. Тухайн үеийн агаарын температур 0°C , чийгийн багтаамж 5 г/м^3 , харьцангуй чийг 80% байсан бол дутмаг чийгийг олоорой. (4 оноо)
- 2.4. Улаанбаатар (7-р цагийн бүс) хотоос Токио (9-р цагийн бүс) хот руу 06 цагт хөөрсөн онгоц Токиод тухайн бүсийн цагаар 13 цагт буужээ. Онгоц хэдэн цаг ниссэн бэ? (4 оноо)